93

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралт*

6 хавсралт

# САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ГАДААД ХАРИЛЦАА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЦАГААНЫ МӨНХЗАЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |

НЭГ. “Салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх” зорилтын хүрээнд

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 1.1 | Арга хэмжээ №1.1. ДЦУБ дахь Монгол Улсын байнгын төлөөлөгчтэй холбогдох асуудлаар шууд харилцаж удирдамж, заавар зөвлөгөө авч, цаг үеийн ажлыг шуурхай зохицуулах: | Асуудлыг хугацаанд нь шийдвэрлүүлсэн байдал, хувиар | Цаг тухайд нь танилцуулж, шийдвэрлүүлсэн байх | ДЦУБ-ын Ажиглалт, дэд бүтэц, мэдээллийн ситемийн комиссын 3 дугаар хуралтай холбоотой асуудлуудыг зохицуулж, газрын дарга, ГХЯ, БОАЖЯ-ны хамтын ажиллагааг хангаж, хуралд албаны дарга цахимаар оролцов. ДЦУБ-аас ирүүлсэн холбогдох албан бичгүүдийг танилцуулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл авч, хэрэгжүүлж ажиллав. Мөн БОАЖЯ-наас шаардсан дэлхийн улс орнуудын цаг уурын албадын өнөөгийн судалгааг гаргаж өгөв.<br><br>Швейцарын Холбооны Улсын Женев хотноо Дэлхийн Цаг уурын байгууллагаас зохион байгуулсан “Шинээр томилогдсон Байнгын төлөөлөгч нарт зориулсан 2024 уулзалт, семинар”-т ЦУОШГ-ын даргыг оролцуулах бэлтгэлийг хангаж ажиллалаа. Тус уулзалт семинарт ЦУОШГ-ын дарга Л.Оюунжаргал оролцох үеэр Дэлхийн Цаг уурын байгууллагын удирдлага, үйл ажиллагаа, холбогдох журам, хөтөлбөрүүдтэй танилцаж, үндэсний |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | | түвшинд хэрэгжих боломжийг судлан Монгол Улсын Цаг уурын байгууллагын үйлчилгээ, техник, тоног төхөөрөмж, технологийн өнөөгийн байдал, цаашдын хэрэгцээ шаардлагын талаар илтгэл тавьсан бөгөөд Дэлхийн Цаг уурын байгууллагын гишүүн байгууллагуудын удирдлагуудтай хамтын ажиллагааны талаар санал солилцож, салбар дундын болон оролцогч талууд хоорондоо туршлага солилцлоо. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% 70 |
| 1.2 | Арга хэмжээ №1.2. Холбогдох конвенцын хэрэгжилтийг хангах, Дэлхийн цаг уурын байгууллагаас баримталж буй бодлого, үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангах | Дэлхийн цаг уурын байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангасан байдал, хувиар | Конвенц, хөтөлбөрүүдийг судалж танилцсан байх, хамааралтай мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, хугацаатай албан захидлуудад хариу хүргүүлсэн байх | Дэлхийн цаг уурын өдрийг тохиолдуулан зохиосон цахим хурал болон ДЦУБ Нисэхийн цаг уурын төвтэй хамтран хэрэгжүүлж буй шинэ нисэх онгоцны буудал дээр суурилуулах нөөц автомат станцын худалдан авалт ба техникийн нөхцлийн талаарх хуралд тус тус цахимаар оролцов. ДЦУБ-ын холбогдох газруудаас ирүүлсэн нийт 77 албан бичгийг холбогдох дарга, мэргэжилтнүүдэд хүргүүлж, санал солилцож ажиллав. ДЦУБ-ын 2024 оны магистрантур, докторантурын тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг орчуулж, байгууллагын цахим хуудаст байршуулж, олон нийтийн группт нийтэллээ. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% 70 |
| 1.3 | Арга хэмжээ №1.3. Гадаад харилцааны асуудлаар удирдах дээд байгууллага, газрын хэлтэс, нэгж, салбарын болон бусад байгууллагатай харилцах, хамтран ажиллах, ажлыг нь уялдуулан зохицуулах, мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | Гадаад хамтын ажиллагааны үр өгөөж дээшилсэн байдал, хувиар | Холбогдох албан тушаалтнуудад мэдээлэл хүргэж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хамтран ажилласан байх | JINSUNG Eng БНСУ-ын цаг уурын багаж, төхөөрөмжийн компанийн мэргэжилтнүүд "Улаанбаатар хотод үерийн прогноз гаргах, сэрэмжлүүлэх систем суурилуулах" төслийн ажлын хүрээнд 5, 9 , 11 дүгээр сард Улаанбаатар хотод тус тус ирж, ЦУОШГ дээр ажилласан бөгөөд газрын хэлтсүүд, БОУАӨЯ, ОБЕГ, НЗДТГ-ын холбогдох албан тушаалтан, төлөөлүүдтэй хамтарсан уулзалт, хурлыг хийв. Энэхүү уулзалт, хурлуудын бэлтгэлийг хангаж, оролцогч талуудын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | | саналыг ТЭЗҮ-д тусгах, холбогдох судалгааны ажилд туслалцаа үзүүлэв.<br><br>Тайландын Хаант Улсын Хааны бороо хөдөө аж ахуй, агаарын тээврийн газрын удирдах албан тушаалтнууд болон мэргэжилтнүүдээс бүрдсэн 9 мэргэжилтэн 5-р сарын 15-19-ний өдрүүдэд ЦУОШГ болон Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран ажилласан бөгөөд энэ хугацаанд зохион байгуулагдсан уулзалт, хурал, семинарыг орчуулж, хамтарч ажиллав. Энэ ажлын хүрээнд ЦУОШГ, УЦУОСМХ, Өмнөговь аймгийн УЦУОШТ-ийн мэргэжилтнүүд болон тус аймгийн ЗДТГ-ийн төлөөлөгч нартай хамтарч ажиллав.<br><br>"Campbell" компанийн Зүүн өмнөд Азийн худалдааны төлөөлөгч Boyd ЦУОШГ-ын мэргэжилтнүүдтэй уулзалт, танилцуулга хийсэн бөгөөд өөрийн компанийн үйлдвэрлэдэг цаг уурын бүхий л төрлийн багаж, хэмжих хэрэгслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх үеэр орчуулга хийсэн.<br><br>Global science and technology компанийг үүсгэн байгуулагч Чиесан Ченг ЦУОШГ-ын "Хүндэт дэвтэр"-т нэрийг мөнхлөх тодорхойлолтыг англи хэл дээр төлөвлөж, Хүндэт өргөмжлөлийн хамт хийж гардуулав.<br><br>БНХАУ-ын пуужин үйлдвэрлэгч "Шанши Зонтиан" компанируу газрын генераторын түлш 300 ширхэг худалдан авах хүсэлтэй байгаа талаар захидал явуулж, өмнөх бүтээгдэхүүнүүдийн үнийг саналыг авч Д. Уламбаяр даргад танилцууллаа. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | | Шанхайн цаг уурын 2 мэргэжилтэн ЦУОШГ, Нисэхийн цаг уурын төв дээр 7 сарын 29-өөс 8 сарын 01-ний өдрүүдэд ажиллаж, “Эрт сэрэмжлүүлгийг хүн бүрд” санаачилгын хүрээнд цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийг прогнозлох, тухайн орон нутагт болдог давтагдал ихтэй үзэгдлүүд дээр нөлөөллийн эрсдэлийн зураг гаргах, олон нийтэд түгээх болон шийдвэр гаргагч нарт зөвлөмж боловсруулдаг “хэрэгсэл”-ийг танилцуулах, хөгжүүлэх уулзалт сургалт хийсэн ба уг сургалтыг зохион байгуулж, орчуулга хийж ажилласан.<br><br>БНФУ-ын Парис хотноо “Францын бизнес” байгууллагаас 2024.10.24-10.25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Прометео, Ус цаг уур” сэдэвт бага хуралд ЦУОШГ-ын даргын оролцох бэлтгэлийг хангаж ажиллав. Тус хурлын үеэр улс орнуудын Цаг уурын байгууллагуудын төлөөллүүд өөрсдийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хэмжлийн арга зүй, хэмжлийн техник тоног төхөөрөмж, технологи, цаашдын хэрэгцээ, шаардлагын талаархи танилцуулга хийсэн. Мөн Францын ус, цаг уурын технологи, үйлдвэрлэлийн болон усны хэмжлийн тоног төхөөрөмжийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай танилцаж, тэдгээртэй уулзалтууд хийж, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор санал солилцлоо.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 70% |
| 1.4 | Арга хэмжээ №1.4. Гадаад арга хэмжээний асуудлаар санал, ЦУОШГ-ын шийдвэрийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх, хамтын ажиллагааны баримт бичгүүдийг боловсруулах, орчуулах, гадаад орнуудын холбогдох | Арга хэмжээг шуурхай авсан байдал, хувиар | Баримт бичиг боловсруулж шийдвэрлүүлж, орчуулга хийж, гадаад орнуудын холбогдох | Ус цаг уурын алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ДЦУБ, Бүсийн II төв, БНСУ, БНХАУ, БНТУ, ОХУ болон бусад хамтарч ажилладаг олон улсын байгууллагуудын төлөөлөлд албан бичиг, урилга хүргүүлсэн бөгөөд 100 жилийн ойн арга хэмжээнд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | байгууллагуудтай санал солилцох, харилцах асуудлыг зохицуулах | | байгууллагуудтай санал солилцсон, харилцах асуудлыг зохицуулсан байх | зориулж ирүүлсэн дүрст болон үгэн мэндчилгээг орчуулж, талархлын хариу захидлуудыг бичиж илгээсэн.<br><br>2024 оны 12 дугаар сарын 3-ны “Бүс ба зам” санаачлагад нэгдсэн орнуудын Хонг конг дахь Уаг уурын сургалтын төвийн нээлтийн ёслолын ажиллагаанд зориулж, ЦУОШГ-ын даргын видео мэндчилгээг тус төвийн Захирал, Доктор CHAN Pak-wai болон нийт хамт олонд хүргэх ажлыг зохион байгууллаа.<br><br>Тайлант онд гадаад улсад салбарын хэмжээнд давхардсан тоогоор 199 албан хаагч, албан томилолтоор ажилласан бөгөөд үүнээс ЦУОШГ-ын 29, УЦУОСМХүрээлэнгээс 44, БОХЗТлабораториос 7, ХЦУТөвөөс 7, орон нутгаас 32 албан хаагчийг гадаад улсад зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулсан.<br><br>Засгийн газраас өгсөн чиг үүргийн дагуу “Монгол орны хэмжээнд урт хугацааны прогноз өндөр нарийвчлалтай гаргах” ажлын хүрээнд АНУ-ын NCEP, Европын дунд хугацааны бүсийн төв болох ECMWF-ийн удирдлагуудад албан бичгээр хүсэлт явуулж, холбогдох хариуг холбогдох удирдлагуудад танилцуулав. Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу цаг агаарын богино хугацааны прогноз мэдээг сайжруулах, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор ЦУОШГ-т 2 ширхэг радар худалдан авах болсонтой холбоотойгоор Япон улс, АНУ, болон Финланд улсын радар угсарч, үйлдвэрлэгч компаниудтай холбогдож, албан бичиг явуулсан ба тус газруудаас ирүүлсэн шийдвэрүүдийг тухай бүрд хэлтсийн даргад танилцуулсан.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 1.5 | Арга хэмжээ №1.5. Цаг уур, орчны шинжилгээний газар, ОХУ-ын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний газрын хооронд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх 9 дүгээр уулзалтын протоколын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах: | Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллээр хангах, орчуулах, дүгнэх, тайлан гаргах зэрэг ажлуудын хэрэгжилтийн хувиар | Холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, уулзалт зохион байгуулах, хугацаатай захидлуудад хариу хүргүүлсэн байх | Олон улсын цаг үеийн нөхцөл байдал /дайн/ болон бусад шалтгааны улмаас 10 дугаар уулзалтын тов гараагүй байгаа болно.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: Үнэлэх боломжгүй. |
| 1.6 | Арга хэмжээ №1.6. БНХАУ-ын Цаг уурын газар болон Монгол улсын Цаг уур, орчны шинжилгээний газрын хооронд Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах Хамтарсан ажлын хэсгийн 17 дугаар уулзалтын протоколын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллээр хангах, орчуулах, дүгнэх, тайлан гаргах зэрэг ажлуудын хэрэгжилтийн хувиар | Холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, уулзалт зохион байгуулах, хугацаатай захидлуудад хариу хүргүүлсэн байх | БНХАУ-ын Цаг уурын албатай Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах хамтарсан ажлын хэсгийн 17 дугаар уулзалтын протоколын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Урт хугацааны прогнозыг хамтран гаргах ажлын хүрээнд БНХАУ-ын Циндао хотод болсон “Азийн бүс нутгийн уур амьсгалын хяналт, үнэлгээ, урьдчилсан төлөв” сэдэвт 20 дугаар хурлад УЦУОСМХ-ийн урт хугацааны урьдчилсан мэдээ хариуцсан ерөнхий инженер Б.Жаргалан ЦУОШГ-ын зардлаар, эрдэм шинжилгээний ажилтан Э. Мөнхжаргал БНХАУ-ын цаг уурын албаны зардлаар тус тус оролцов. Мөн уг протоколын хүрээнд БНХАУ-ын цаг уурын албаны мэргэжилтнүүд Монгол улсад ирж ажиллах, ЦУОШГ-аас студийн 1 мэргэжилтэнг БНХАУ-д туршлага солилцохоор илгээх ажлын хүсэлтийг хүргүүлэн ажиллав.<br>ЦУОШГ-ын мэдээллийн студийн ахлах мэргэжилтэн М. Батжаргал уг протоколын хэрэгжилтийн хүрээнд 10-р сарын 23-27-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо цаг агаарын мэдээллийн студийн бүтээгдэхүүн гаргах, олон нийтэд түгээх мөн шинэлэг технологи ашиглах талаар Хятадын Цаг уурын газарт зочилж, туршлага судласан.<br>ЦУОШГ-ын УМХ-ийн инженер О. Өнөртуул, УЦУОСМХ-ийн ХАА хэлтсийн инженер Г. Раднаа нар БНХАУ-ын Гуанжоу хотноо зохион байгуулагдсан “Тропикын циклоныг урьдчилан мэдээлэх нь” сэдэвт олон улсын сургалтад хамрагдсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: Биелэлтийн хувь: |

66

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | | 2024.01.01-2024.12.05 100% |
| 1.7 | Арга хэмжээ №1.7. Монгол улсын Цаг уур, орчны шинжилгээний газар, БНСУ-ын Цаг уурын газрын хооронд цаг уурын салбарт хамтран ажиллах 10 дугаар уулзалтын протоколын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд Цаг агаарын тоон прогнозын дэлхийн болон бүс нутгийн загварыг сайжруулах, Цаг уурын мэдээллийн нэгдсэн систем үүсгэх, Өвөрхангай аймгийн төвд аэрологийн судалгааны станц суурилуулах талаар хамтран ажиллах | Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллээр хангах, орчуулах, дүгнэх, тайлан гаргаж танилцуулах зэрэг ажлуудын хэрэгжилтийн хувиар | Холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, уулзалт зохион байгуулах, хугацаатай захидлуудад хариу хүргүүлсэн байх | БНСУ-ын цаг уурын алба, ЦУОШГ-ын хооронд цаг уурын салбарт хамтран ажиллах асуудлаар байгуулсан 10 дугаар уулзалтын протоколын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд хэрэгжүүлж буй "Цаг уурын мэдээллийн нэгдсэн систем үүсгэх, Өвөрхангай аймгийн төвд аэрологийн судалгааны станц суурилуулах" төслийн ажил хэрэгжилтийн шатандаа явж буй бөгөөд БНСУ-ын 3 мэргэжилтэн энэ оны 11 дүгээр сараас 12 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл Өвөрхангай аймагт ажиллаж байна. Мөн энэхүү төслийн хүрээнд ЦУОШГ-ын 8 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй баг 7 сарын 28-аас 8 сарын 03-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо Солонгосын цаг уурын хүрээлэнгээс зохион байгуулж буй "Монгол улсад цаг уурын ажиглалтын мэдээллийн нэгдсэн систем суурилуулах нь" сэдэвт сургалтад хамрагдав.<br>Дэлхийн болон бүс нутгийн загварыг сайжруулах, урт хугацааны цаг агаарын прогнозыг бүсийн хэмжээнд хэлэлцэх зорилгоор БНСУ-ын Дажеон хотноо зохион байгуулагдсан EASCOF-12 хурвлд УЦУОСМХ-ийн судлаач Мөнхжаргал, Б. Жаргалан нар оролцсон ба манай улсаас оролцсон нэг мэргэжилтний зардлыг БНСУ-ын цаг уурын талаас бүрэн хариуцав.<br>Цаг уурын багажийн гэрчилгээ олгох "Техникийн солилцоо"-ны олон улсын хуралд УСУАУХ-ийн дарга Д. Уамбаяр, Лабораторийн мэргэжилтэн Б. Цэрэндорж нар БНСУ-ын Чонжү, Бусан хотноо 9-р сарын 02-06-ны хооронд оролцсон.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% 70 |
| 1.8 | Арга хэмжээ №1.8. Цаг уур, орчны шинжилгээний газар болон Тайландын Хааны бороо, хөдөө аж ахуйн агаарын тээврийн газар хооронд "Цаг агаарт зориудаар нөлөөлөх талаарх техникийн хамтын ажиллагааны | Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллээр хангах, орчуулах, дүгнэх, тайлан гаргаж танилцуулах зэрэг | Холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, уулзалт зохион байгуулах, хугацаатай | Хамтарсан хөтөлбөрийг 2021 оны 09 дүгээр сард Тайландын Хаант улсын Хааны бороо, хөдөө аж ахуй, агаарын тээврийн газар болон ЦУОШГ-ын хооронд техникийн хамтын ажиллагааны хамтарсан хөтөлбөрийг байгуулсан бөгөөд нийтдээ 3 жилийн хугацаатай |

100

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | хамтарсан хөтөлбөр"- ийн хэрэгжилтийг ханган ажиллах | ажлуудын хэрэгжилтийн хувиар | захидлуудад хариу хүргүүлсэн байх | хэрэгжиж, хөтөлбөр дууссан. 2024 оны 05 дугаар сарын 16-19-ний хооронд тус улсын нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжилтнүүд ЦУОШГ-т айлчлал хийсэн бөгөөд уг айлчлалаар энэхүү хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, мөн 2027 он хүртэл сунгах ажлууд хийгдэв. Үүний хүрээнд 05 дугаар сарын 16-ны өдөр ЦУОШГ дээр хамтарсан хурал хийж, холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан ба 2021-2024 оны хооронд цаг агаарт зориудаар нөлөөлөхөд шаардлагатай арга зүй, технологийн сургалтууд зохион байгуулсан талаар Тайланд ба манай улсын мэргэжилтнүүд хэлэлцсэн бөгөөд үүний дүнд хамтын ажиллагааны хөтөлбөрийг сунгах шийдвэр гарч, ЦУОШГ-ын ахлах маргэжилтэн Г. Амгалан, ахлах мэргэжилтэн С. Жавзмаа УЦУОСМХ-ын ЦАОТЗСХ-ийн дарга Г. Батжаргал нарыг тус хөтөлбөрийн ажлын хэсгийн багт оруулсан ба төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, туршлага солилцож ажиллахаар болов.<br><br>Мөн Өмнөговь аймгийн ЗДТГ-ын гаргасан хүсэлтийн дагуу тус аймагт сүүлийн жилүүдэд хур тунадас бага, ган гачиг нүүрлэж буйтай холбоотойгоор Тайланд улсын Хааны борооны газрын мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах санал тавьж, мэргэжилтний баг 17, 18-ны өдрүүдэд Өмнөговь аймагт ажиллаж, хамтарсан хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн төлөөлөгч нартай хур бороо нэмэгдүүлэх технологийг нэвтрүүлэх чиглэлээр хамтарч ажиллахаар болов. Уг төсөл 2024-2027 оны хооронд хэрэгжих ба эхний жил суурь судалгаа, хоёр дахь жил технологи судалж сонгох, харин |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | | сүүлийн жилд өмнөх 2 жилээс гарсан үр дүнд тулгуурлан тайлан, гарын авлага гаргах байдлаар хэрэгжинэ.<br><br>Тус өдрүүдэд Өмнөговь аймгийн УЦУОШТөв дээр ажилласан ба цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаатай танилцаж, туршилтын пуужин харвасан. Энэхүү айлчлалтай холбоотой мэргэжилтнүүдийг хүлээн авах, хурал зохион байгуулах, орчуулах ажлуудыг хийж гүйцэтгэж, хамтарч ажиллав.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| 1.9 | Арга хэмжээ №1.9. Олон улсын стандартын шаардлагыг хангасан ус, цаг уурын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч компанитай хамтран ажиллах | 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилт хувиар | Хамтран ажиллах гэрээний төсөл бичих, батлуулсан байх | БНХАУ-ын “Beijing Auxin Chemical Technology” компанид борооны пуужинг гаалиар нэвтрүүлэхэд шаардлагатай нэмэлт албан бичгүүдийг МУ-ын ГХЯ, Гаалийн ерөнхий газар, БНХАУ-д суугаа МУ-ын Элчин сайдын яам, ӨМӨЗО-ны Гаалийн газруудад хүргүүлж, пуужингийн лицензийн сунгалтыг хийлгэсний дагуу 7 сарын 10-нд 1150 пуужин, 22 ширхэг пуужин хөөргөгчийн удирдлагыг боомтоор оруулахаар болов. Францын “MODEM” компанитай 1400 зонд худалдан авах гэрээ байгуулж, гэрээг орчуулах, төлбөрийг шилжүүлэх, зондыг хүлээж авахад шаардлагатай материалыг бүрдүүлэв. Финландын “Vaisala Oyj” компанитай цаг уурын хэмжих хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсан. Хэмжих хэрэгслийг хүлээн авч худалдан авах ажиллагаа явагдаж байна. Англи улсын eOsphere Limited компанитай программ хангамжийн техник үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхэд шаардлагатай материалыг бүрдүүлэв.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| 1.10 | Арга хэмжээ №1.10. Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын (хилийн усыг ашиглах, хамгаалах тухай) хэлэлцээрийн дагуу мэдээ, мэдээлэл солилцох: | Мэдээ, мэдээлэл солилцсон эсэх | Мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэж, шаардлагатай үед ажлын явцын талаар | Хяналт-шинжилгээний 2023 оны үр дүнг нэгтгэн тайланг 2023 оны 3 дугаар сарын 12-ны өдөр ОХУ-ын ажлын хэсэгт имэйлээр илгээв.<br>Эхэлсэн, дууссан огноо: Биелэлтийн хувь: |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | ОХУ-ын талд мэдээлж байх | 2024.01.01-2024.06.01 100% |
| 1.11 | Арга хэмжээ №1.11. Салбарын мэргэжилтнүүдийг гадаадад сургах, давтан сургах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих | Мэдээллээр хангах, хамрагдах мэргэжилтнүүдийн материал илгээх, сургалттай холбоотой ажлыг зохион байгуулах зэрэг ажлуудын хэрэгжилтийн хувиар | Холбогдох салбар, хэлтсүүдэд мэдээлэл хүргэх, холбож өгөх, тушаал гаргуулах, сургалтад оролцсон мэргэжилтнээр тайлан гаргуулах, хагас жилийн тайлан гаргах | ДЦУБ-ын сургалтууд, БНЭУ-ын богино болон 9 сарын сургалтууд, БНХАУ-ын ЦУГ болон Нанжин хотын Техникийн их сургууль болон БНСУ-ын ЦУГ дахь бүсийн сургалтын төвийн богино сургалт, сургалтын мэдээллийг холбогдох удирдлагуудад танилцуулж, сургалтад нэр дэвшүүлэх албан бичгүүдийг боловсруулж илгээв.<br>БНСУ-ын ЦУГ-т 3 хүнийг “Синоптик инженерүүдэд зориулсан цаг агаарын прогноз” сэдэвт танхимын сургалтад хамруулав. Тайланд улсын Хааны бороо хөдөө аж ахуй, агаарын тээврийн газрын хамтарсан хөтөлбөрийн хүрээнд 9 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжилтнүүд цаг агаарт зориудаар нөлөөлөх, тунадас нэмэгдүүлэх чиглэлийн богино хугацааны сургалтад оролцов.<br>Шанхайн цаг уурын төв, ЦУОШГ, Нисэхийн цаг уурын төвийн мэргэжилтнүүдээс бүрдсэн “Олон төрлийн гамшигт үзэгдлээс эрт сэрэмжлүүлэх хэрэгсэл” нэртэй цахим сургалт, хэлэлцүүлэгт оролцов. Солонгос Улсын Инчон хотын Сонгдо дүүрэгт байрлах НҮБ-ын Гамшгийн Эрсдлийг Бууруулах Газрын (UNDRR) Дэлхийн Боловсрол, Сургалтын Институт дээр “Гамшигт өртөх эрсдлийг бууруулах, цаг уурын мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийн системийн хэрэгсэл (Монгол, Бутан улсын суралцагч нарын сургалт) болон суралцаж буй мэдлэгээ төслийн санал болгоход хэрэглэх талаар нэмэлт санал бичих семинар” 2024 оны 8-р сарын 26-30-нд зохион байгуулагдлаа. Семинарт Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2, Цаг уур орчны шинжилгээний газраас 3, Сангийн яамнаас 1, Зориг сангаас 2, Онцгой байдлын ерөнхий газраас 4, Байгаль хэмгаалах сангаас 2, Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс 1, Нисэхийн цаг уурын төвөөс 1 мэргэжилтэн тус тус хамрагдав.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: Нийт 700 Биелэлтийн хувь: 70% |

103

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | | 2024.01.01-2024.12.05 100% |
| 1.12 | Арга хэмжээ №1.12. Хамтын ажиллагааны хүрээнд зохиогдох хоёр болон олон талын уулзалтын бэлтгэлийг хангах, протоколын хэрэгжилтийг хангуулах, олон улсын байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн, уулзалт, семинар зохион байгуулах | Цаг хугацаанд нь мэдээллээр хангах, бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах зэрэг ажлуудын хэрэгжилтийн хувиар | Холбогдох салбар, хэлтсүүдэд мэдээлэл хүргүүлэх, бэлтгэл хангах, тушаал гаргуулах, холбогдох төсөл хөтөлбөрийн хагас жилийн тайланд тусгасан байх | БНСУ, БНХАУ, Тайланд улсын цаг уурын алба болон бусад холбогдох байгууллагуудтай хоёр болон олон талын уулзалтын бэлтгэлийг хангах, протоколын хэрэгжилтийг хангуулах талаар анхаарч ажиллаж байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| ХОЁР. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд | | | | |
| 2.1 | Арга хэмжээ №2.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмыг хэрэгжүүлж ажиллах, Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд гарсан тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллах | Боловсруулсан төлөвлөгөө, ажлын тайлан<br>Зөрчил гаргалгүй ажилласан байдал | ТЖАХ-ын 2023 оны төлөвлөгөө батлуулах, улирлын тайлан өгөх, хэлтсийн төлөвлөгөөний биелэлтэд ажлын тайлангаа тусгуулах, Хууль, тогтоол хэрэгжсэн, дүрэм, журам мөрдсөн байх | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу ТЖАХ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулав. ТЖАХ-ын улирал, хагас жил болон жилийн эцсийн тайланг заасан хугацаанд гаргав. Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд гарсан тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| 2.2 | Арга хэмжээ №2.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Төрийн албаны тухай хууль холбогдох бусад хууль, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх | Зөрчил гаргалгүй ажилласан байдал | Хууль, тогтоол, журам, дүрэм хэрэгжсэн байх | Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Төрийн албаны тухай хууль холбогдох бусад хууль, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллав.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| 2.3 | Арга хэмжээ №2.3. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Олон улсын гэрээний тухай хууль, Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам болон бусад холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах | Зөрчил гаргалгүй ажилласан байдал | Хууль, тогтоол хэрэгжсэн, дүрэм, журмыг мөрдөж ажилласан байх | Гадаад бодлогын үзэл баримтлал, Олон улсын гэрээний тухай хууль, Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам болон бусад холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллав.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| 2.4 | Арга хэмжээ №2.4. Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж, тайлагнах, Байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцох | Үүрэг даалгавар гүйцэтгэсэн, үйл ажиллагаанд оролцсон байдал | Үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэсэн байх. идэвхтэй оролцсон байх | Газар, хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгавруудыг тухай бүр шуурхай гүйцэтгэв. “Өвлийг өнтэй давцгаая” аяны хүрээнд хэлтсийн хамт олны хийх ажлын хуваарь, төсвийг гаргаж тухайн арга хэмжээг амжилттай зохион байгуулж, хамт олноос “Маш сайн” үнэлгээ авлаа. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | | ЦУОШГ-ын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бүтээлч ажлын хүрээнд хэлтсийн хамт олон дугуйн зогсоол хийх амлалт авсны дагуу хийж байршууллаа.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| 2.5 | Арга хэмжээ №2.5. Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийн дагуу ХАСХОМ-г хугацаанд нь үнэн зөв мэдүүлэх | Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн байдал | Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн байх | ХАСХОМ-г шинээр томилогдсон даруйдаа нь үнэн зөв мэдүүлсэн болно.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 50% |

ГУРАВ. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| | Арга хэмжээ №1. Төрийн албан тушаалд тавигдах шаардлагуудыг хангаж ажиллахын тулд холбогдох хууль, журам уншиж судлах, өөрийгөө хөгжүүлэх | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль хэрэгжүүлэх | ДЦУБ-ын албан ёсны вэб сайтын мэдээллийг байнга уншиж судлан, салбарын болон мэргэжлийн хэллэгийг англи, орос хэлнээ хөрвүүлэн өөрийгөө хөгжүүллээ.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| | Арга хэмжээ №2.Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтуудад шат дараатай хамрагдах | Хичээлийн агуулгыг бүрэн судалж төгсөх | Удирдлагын академийн магистрантурт суралцаж дүүргэн урьдчилсан хамгаалалтад амжилттай тэнцэж, ДМА-ны зөвлөлөөр Магистрантурын судалгааны ажлыг 12 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлж, хамгаалахаар бэлтгэж байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |
| | Арга хэмжээ №3.Гадаад харилцаа, дипломат ёс, хамтын ажиллагааны мэдлэгээ дээшлүүлэх, бие даан суралцах, сургалтад хамрагдах | Цахим хичээл судлах, сургалтад хамрагдсан тохиолдолд хичээлийн агуулгыг бүрэн судалж төгсөх | ОХУ-ын ижил төөстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт тавин ажиллаж, судалгааг хийж байна. |

105

| | | |
|---|---|---|
| | | Гадаадын зочид, төлөөлөгчдийг хүлээн авах, үдэх, хамтын ажиллагааны баримт бичиг байгуулахад баримтлах дипломат ёслолын талаарх мэдлэгээ бататган судалж, бие даан суралцаж байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-2024.12.05 Биелэлтийн хувь: 100% |

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ №1. 100 жилийн ойн хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст ажиллаж байсан дарга, мэргэжилтнүүдийн уулзалтыг зохион байгуулж, баримтат киноны бичлэг хийхэд оролцов. | Зохион байгуулсан ажлын тоо | - | 10 | Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр ажиллаж байсан 10 хүнийг урьж ажлын туршлага, хүрсэн үр дүнгийн талаар дурсамж яриаг баримтат киноны бичлэгт оруулллаа. | 2024.01.01-2024.03.05 | 100% 70 |
| 2. | Арга хэмжээ №2. Салбарын 100 жилийн ойн номонд оруулах гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүх, 2 ба олон талт хамтын ажиллагааны талаар текст бэлтгэх | Материалын тоо | - | 5 | Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүх, 2 ба олон талт хамтын ажиллагааны талаар талаар мэдээлэл бэлтгэн номонд оруулллаа. | 2024.03.01-2024.04.01 | 100% 70 |
| 3 | Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Хөвсгөл аймгийн УЦУОШТ-д ажиллах | Ажилласан орон нутгийн байгууллагын тоо | - | 3 | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 4.2, 4.4 дэх зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх холбогдох арга хэмжээний санал боловсруулах, Хөвсгөл аймгийн Ус, цаг уурын салбарын үйл ажиллагаа, цаг үеийн нөхцөл байдалтай танилцаж, байгаль | 2024.09.26-2024.10.04 | 100% 70 |

106

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг танилцуулах зорилгоор Хөвсгөл аймгийн УЦУОШТ, Төмөрбулаг, Жаргалант, Шинэ-Идэр сумдад 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд ажиллаж, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын санал, хүсэлтийг сонсож, бодлого, аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа. | | |
| 4 | Томилогдсон ажлын хэсэгт ажиллаж, хуваарьт ажлыг шуурхай, чанартай гүйцэтгэх | Хэрэгжилтийн хувь | - | 1 | ЦУОШГ-ын даргын 2024.11.22-ны өдрийн А/321 дүгээр тушаалаар баталсан УЦУОХШ-ний салбарт 2024 онд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэгчээс хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан Зөвлөх үйлчилгээ, Чанарын тогтолцооны ISO-90012015 ЦУОШГ/2024060104 сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа. | | 100% 70 ✓ |

ТАЙЛАН ГАРГАСАН:
Гадаад харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
( Албан тушаал )

Ц.Мөнхзаяа / ........................... /
( Нэр, гарын үсэг )

2024-12-05
( Огноо )

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЦАГААНЫ МӨНХЗАЯАГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

**Байгууллагын нэр:** ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

**Нэгжийн нэр:** САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛАГААНЫ ХЭЛТЭС

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| Зорилт 1. “Салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 1.3. | 40 | 10 | 50 | |
| 4. | Арга хэмжээ 1.4. | 60 | 10 | 70 | |
| 5. | Арга хэмжээ 1.5. | — | — | — | |
| 6. | Арга хэмжээ 1.6. | 60 | 10 | 70 | |
| 7. | Арга хэмжээ 1.7. | 60 | 10 | 70 | |
| 8. | Арга хэмжээ 1.8. | 60 | 10 | 70 | |
| 9. | Арга хэмжээ 1.9. | 60 | 10 | 70 | |
| 10. | Арга хэмжээ 1.10. | — | — | — | |
| 11. | Арга хэмжээ 1.11. | 60 | 10 | 70 | |
| 12. | Арга хэмжээ 1.12. | 60 | 10 | 70 | |
| Зорилт 2. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 2.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 2.3. | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 2.4. | 60 | 10 | 70 | |
| 5. | Арга хэмжээ 2.5. | 60 | 10 | 70 | |
| Зорилт 3. “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 3.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 3.3. | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1. 100 жилийн ойн хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст ажиллаж байсан дарга, мэргэжилтнүүдийн уулзалтыг | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, баримтат киноны бичлэг хийхэд оролцсон. | | | | |
| 2. | Арга хэмжээ 2. Салбарын 100 жилийн ойн номонд оруулах гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүх, 2 ба олон талт хамтын ажиллагааны талаар текст бэлтгэсэн. | 50 | 10 | 60 | |
| 3. | Арга хэмжээ 3. Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Хөвсгөл аймгийн УЦУОШТ-д ажилласан. | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 4. Томилогдсон ажлын хэсэгт ажиллаж, хуваарьт ажлыг шуурхай, чанартай гүйцэтгэсэн. | 60 | 10 | 70 | |
| | **Дундаж оноо:** | 2х70=140 | | 68. | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. Засгийн газрын 278 тогтоол | 80 | 12/16 | |
| 2. | Арга хэмжээ 2 | 80 | 12/15 | |
| | **Дундаж оноо** | | 12.0/6 9.0 | ~~10,3~~ 9,0 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 6 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | 5 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | 6 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 6 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 6 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| | **Дундаж оноо** | 6.8 | 5,8 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7.0 |
| 2. | Багаар ажиллах | 7.1 |
| 3. | Харилцаа | 6.4 |
| | **Дундаж оноо** | 6.8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | (70 хүртэлх оноо) 68 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | (15 хүртэлх оноо) ~~10~~ ~~10,5~~ 9 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | (7 хүртэлх оноо) ~~6.8~~ 5,8 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | (8 хүртэлх оноо) 6.8 6,8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | (..... оноо) |
| | **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | ~~91,6~~ 89,6. |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

СТХАХ-ийн дарга ........М.Гал........ /Н.Галцог /
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
.............................. *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Ахлах мэргэжилтэн ..................... /Ц.Мөнхзаяа/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
...................... *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ЗАХ-ын дарга, Үнэлгээний багийн дарга ...................... /Р.Бадмаадорж/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
2024.12.16 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн ...................... /Ж.Энхчимэг/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
2024.12.16 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Газрын дарга ........................... /Л.Оюунжаргал/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
2024.12.17 *(огноо)*

① Тайланд - бичиг хэргийн стандарт хангаагүй.

② Гүйцэтгэлийн төлөвлөгөөг сайжруулах.